

## МӨНГӨНИЙ ТОЙМ

2017 оны 3 дугаар сар

ХУРААНГУЙ:

- Мөнгөний нийлүүлэлт өмнөх сард 3.2%-иар өссөн бол энэ сард 0.6%-иар буурч 12.2 их наяд төгрөг болжээ.
- Төгрөгийн харилцах, хадгаламж өссөн бол валютын харилцах, хадгаламж болон хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө буурсан байна.
- Сүүлийн саруудын гадаад валютын хадгаламж буурч, төгрөгийн хадгаламж нэмэгдэх хандлага үргэлжилж байна.
- Хадгаламжийн байгууллагаас гадуурх болон банкуудын касс дахь мөнгө буурч Төв банк дахь харилцах өссөнөөр нөөц мөнгө бага зэрэг өсч 2.7 их наяд төгрөг болжээ.
- Нийт санхүүгийн байгууллагуудаас зээлийн үлдэгдэл өмнөх сараас өсч 16.8 их наяд төгрөгт хүрчээ. Үүний 49 хувь иргэдэд, 45 хувь хувийн хэвшилд олгосон зээл байна.
- Санхүүгийн байгууллагуудын зээлийн 10.1 хувь нь хугацаа хэтэрсэн, 7.6 хувь нь чанаргүй зээл байна.
- Улаанбаатар хотын сарын инфляци хүнсний бараа бүтээгдэхүүний үнийн өсөлтөөс голлон шалтгаалжээ.

## МӨНГӨ, САНХҮҮГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

	2016				2017		
	3-р сар	6-р сар	9-р сар	12-р сар	1-р сар	2-р сар	3-р сар
<b>Инфляци</b>							
Улаанбаатар хотын сарын	0.3	-0.5	-0.9	0.9	1.3	0.8	1.3
оны эхнээс	1.5	2.7	0.1	0.5	1.3	2.1	3.4
жилийн	<b>1.1</b>	<b>1.2</b>	<b>-0.7</b>	<b>0.5</b>	<b>1.4</b>	<b>1.4</b>	<b>2.3</b>
Суурь сарын	-0.4	-0.1	0.3	0.3	0.1	0.3	0.0
оны эхнээс	-1.1	-1.2	-1.0	0.5	0.1	0.4	0.4
жилийн	<b>3.1</b>	<b>3.0</b>	<b>0.8</b>	<b>0.5</b>	<b>1.0</b>	<b>1.7</b>	<b>2.1</b>
Улсын сарын	0.5	-0.3	-0.6	0.7	1.2	0.9	0.9
оны эхнээс	1.7	2.9	0.6	1.1	1.2	2.1	3.1
жилийн	<b>1.7</b>	<b>1.6</b>	<b>-0.1</b>	<b>1.1</b>	<b>1.9</b>	<b>2.1</b>	<b>2.5</b>
<b>Мөнгө, санхүүгийн сектор</b>							
Нөөц мөнгө, сая ₮	2,422,256.5	3,584,981.9	3,164,886.1	3,487,656.0	2,712,102.5	2,675,173.0	2,749,861.6
сарын өөрчлөлт, хувиар	2.2	9.8	-4.8	-1.7	-11.5	-1.4	2.8
жилийн өөрчлөлт, хувиар	-4.9	47.5	27.1	38.4	17.5	15.9	17.0
M2 мөнгө, сая ₮	10,112,436.2	11,186,374.0	11,555,864.1	12,076,501.7	11,880,661.8	12,257,201.8	12,189,279.9
сарын өөрчлөлт, хувиар	1.0	5.0	1.6	3.0	-1.6	3.2	-0.6
жилийн өөрчлөлт, хувиар	2.1	11.4	16.3	20.2	20.6	22.4	20.5
Бусад хадгаламж, сая ₮	8,528,699.5	9,204,169.0	9,535,322.2	9,986,377.6	9,928,266.8	10,112,179.4	10,106,185.8
сарын өөрчлөлт, хувиар	0.5	3.3	1.5	1.9	-0.6	1.9	-0.1
жилийн өөрчлөлт, хувиар	0.9	9.9	14.6	19.4	20.5	19.1	18.5
Гүйлгээнд байгаа бэлэн мөнгө, сая ₮	658,588.9	839,237.9	795,795.9	823,629.3	736,068.2	944,705.5	788,251.9
сарын өөрчлөлт, хувиар	0.5	6.5	-2.6	7.1	-10.6	28.3	-16.6
жилийн өөрчлөлт, хувиар	-6.3	11.0	3.6	16.6	3.1	44.1	19.7
Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮	18,430,337.9	18,410,238.6	19,240,122.0	16,449,122.3	16,367,469.2	16,709,725.8	16,823,998.4
сарын өөрчлөлт, хувиар	1.5	1.7	0.6	-16.7	-0.5	2.1	0.7
жилийн өөрчлөлт, хувиар	11.5	8.1	8.0	-8.3	-9.4	-7.9	-8.7
Хадгаламжийн байгууллагуудын зээлийн үлдэгдэл, сая ₮	11,835,465.1	12,030,355.9	12,490,873.6	12,422,235.9	12,379,495.2	12,583,529.0	12,678,043.4
сарын өөрчлөлт, хувиар	1.7	5.1	0.4	-2.3	-0.3	1.6	0.8
жилийн өөрчлөлт, хувиар	-3.6	0.6	4.6	6.1	5.0	8.1	7.1
Хад. байгууллагуудын чанаргүй зээлийн үлдэгдэл, сая ₮	967,863.5	1,035,568.5	1,119,261.8	1,051,680.5	1,056,150.4	1,070,100.6	1,035,475.9
сарын өөрчлөлт, хувиар	6.2	-2.6	-0.6	-9.9	0.4	1.3	-3.2
жилийн өөрчлөлт, хувиар	37.7	33.8	31.3	20.9	18.1	17.5	7.0
Мөнгөний үржүүлэгч	4.2	3.1	3.4	4.0	4.4	4.6	4.4
<b>Хүү</b>							
Хадгаламжийн ЖДХ	13.3	13.3	13.2	13.1	13.4	13.3	13.0
Хадгаламжийн бодит хүү*	12.2	12.1	13.8	12.6	12.0	11.9	10.7
Зээлийн ЖДХ**	19.7	19.1	20.1	19.7	20.2	20.1	20.2
Зээлийн бодит хүү*	18.6	18.0	20.8	19.2	18.8	18.7	17.8
Ипотекийн зээлийн хүү	8.8	7.7	8.7	10.3	9.6	10.3	10.3
ТБҮЦ-ны ЖДХ	12.0	10.5	16.0	14.5	14.0	14.0	14.0
Бодлогын хүү	12.0	10.5	15.0	14.0	14.0	14.0	14.0
БХЗ-ын ЖДХ	12.6	11.3	15.9	15.5	14.5	14.9	15.0

\* Улаанбаатар хотын хэрэглээний барааны үнийн индексээр тооцсон

\*\* Төгрөгийн зээлийн жигнэсэн дундаж хүү

Мөнгөний нийлүүлэлт


Тухайн сард **M2** мөнгөний нийлүүлэлт 0.6 хувь буюу 67.9 тэрбум төгрөгөөр буурч 12.2 их наяд төгрөг болжээ. Үүнд M1 мөнгө 2.9 хувиар буурсан нь голлон нөлөөлөв.

**M1** мөнгөний бүрэлдэхүүн хэсгээс төгрөгийн харилцах 44.9 тэрбум төгрөгөөр өсч, хадгаламжийн байгууллагаас гадуурх мөнгө 106.8 тэрбум төгрөгөөр буурсан байна.


**Бусад хадгаламж, харилцах\*-ын өөрчлөлт** харьцангуй бага буюу 0.1 хувиар буурсан боловч бүрэлдэхүүн хэсгүүдийг харвал төгрөгийн хадгаламж 173.5 тэрбум төгрөгөөр өсч, валютын хадгаламж 67.5 тэрбум төгрөгөөр, харилцах 111.9 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна. Сүүлийн саруудад иргэд, байгууллагын хувьд гадаад валютын хадгаламжаа төгрөгийн хадгаламжинд шилжүүлэх хандлага үргэлжилсэн хэвээр байна. Тухайлбал банкин дахь иргэдийн гадаад валютын хадгаламж 55.2 тэрбум төгрөгөөр буурсан бол байгууллагын валютын хадгаламж 12.3 тэрбум төгрөгөөр буурчээ.

Төгрөгийн ам.доллартай харьцах ханшийн өөрчлөлтийн нөлөөг хасч тооцвол гадаад валютын хадгаламж өмнөх сараас ойролцоогоор 2.1 хувиар, гадаад валютын харилцах 7.2 хувиар тус тус буурчээ.

Зураг 1. Мөнгөний нийлүүлэлтийн задаргаа



Зураг 2. Мөнгөний үзүүлэлтүүдийн сарын өөрчлөлт, тэрбум ₮



Зураг 3. Хадгаламжийн үлдэгдэл (иргэд, байгууллага)



\*Хуучнаар бараг мөнгө

## Гадаад, дотоод актив


Мөнгөний нийлүүлэлтийг байршуулалт талаас авч үзвэл хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив өмнөх сараас 50.6 тэрбум төгрөгөөр, дотоод цэвэр актив 17.4 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Гадаад цэвэр активын өөрчлөлтөд Төв банкны гадаад цэвэр актив 198.7 тэрбум төгрөгөөр өсч, бусад хадгаламжийн байгууллагуудын гадаад цэвэр актив 249.2 тэрбум төгрөгөөр буурсан нь нөлөөлөв.

Дотоод цэвэр авлага өмнөх сараас 8.6 тэрбум төгрөгөөр буурч 17.5 их наяд төгрөг болжээ. Иргэдээс авах авлага 79.6 тэрбум төгрөг, хувийн хэвшлээс авах авлага 32.2 тэрбум төгрөгөөр өссөн байхад Засгийн газраас авах цэвэр авлага 91.5 тэрбум төгрөгөөр, бусад санхүүгийн байгууллагаас авах авлага 18.4 тэрбум төгрөгөөр буурсан байна.

Тайлант сард нөөц мөнгө 74.7 тэрбум төгрөгөөр өсч 2749.9 тэрбум төгрөг болжээ. Банкуудын Төв банк дахь харилцах 231.1 тэрбум төгрөгөөр өссөн бол хадгаламжийн байгууллагуудаас гадуурх мөнгө 106.8 тэрбум төгрөгөөр, банкуудын касс дахь мөнгө 49.7 тэрбум төгрөгөөр тус тус буурсан байна.

Зураг 4. Хадгаламжийн байгууллагуудын гадаад, дотоод цэвэр актив



Зураг 5. Нөөц мөнгө



## Санхүүгийн байгууллагын зээл

Санхүүгийн байгууллагуудаас олгосон зээлийн үлдэгдэл өмнөх сараас 114.3 тэрбум төгрөгөөр өсч 16.8 их наяд төгрөг болжээ.


Санхүүгийн секторын зээлийн өсөлтийн 94.5 тэрбум төгрөг нь банкуудын зээлийн өсөлт, харин 19.8 тэрбум төгрөг нь бусад санхүүгийн байгууллагын (голчлон МИК ОССК)-ын зээлийн өсөлт байна.

Нийт санхүүгийн байгууллагуудын зээлийн 75.4 хувийг хадгаламжийн байгууллагууд, 24.6 хувийг бусад санхүүгийн байгууллагуудын олгосон зээл бүрдүүлж байна. Нийт зээлийн 48.7 хувийг иргэдэд, 45.0 хувийг хувийн хэвшилд, 6.3 хувийг улсын байгууллагуудад олгожээ.


Санхүүгийн байгууллагуудын зээлийн үлдэгдэлд хугацаа хэтэрсэн зээлийн эзлэх хувь өмнөх сараас 0.4 нэгж хувиар буурч 10.1 хувь болжээ. Харин чанаргүй зээлийн хувь өмнөх сараас 0.1 нэгж хувиар өсч 7.6 хувьд хүрэв. Хугацаа хэтэрсэн зээлийн 72.9 хувь, чанаргүй зээлийн 80.4 хувь нь хувийн хэвшилд олгосон зээл байна.

Харин хадгаламжийн байгууллагуудын зээлийн хувьд хугацаа хэтэрсэн зээл 7.8 хувь, чанаргүй зээл 8.2 хувийг эзэлж байна. Татан буугдсан банкуудын мэдээллийг хасч тооцвол чанаргүй зээл 6.6 хувийг эзэлж байна.

Зураг 6. Санхүүгийн байгууллагуудын зээл



Зураг 7. Санхүүгийн байгууллагын хугацаа хэтэрсэн болон чанаргүй зээл






**Валютын ханш**

Тайлант сарын эцэст Монголбанкнаас зарласан төгрөгийн ам.доллартай харьцах ханш 0.9 хувь буюу 23.4 төгрөгөөр чангарч 2447.5 болжээ. Тухайн сард төгрөгийн ам.доллартай харьцах дундаж ханш 2459.6 төгрөг байв. 2017 оны 3 дугаар сарын эцэст төгрөгийн евротой харьцах ханш 2616.8, Хятадын юаньтай харьцах ханш 355.2, ОХУ-ны рубльтай харьцах ханш 43.7 байв.

Тайлант сард төгрөгийн нэрлэсэн үйлчилж буй ханшийн индекс 0.8 хувиар өссөн буюу төгрөгийн гадаад валюттай харьцах ханш энэ хэмжээгээр чангарсан байна.

**Зураг 10. Төгрөгийн гадаад валюттай харьцах ханшийн индекс, 2010.12.31 = 100**



**Инфляци**

2017 оны 3 дугаар сарын инфляци УБ хотын хэмжээнд 1.3 хувь байгаа нь хүнсний барааны үнийн өөрчлөлтөөс голлон шалтгаалжээ. Харин хүнсний барааны үнэ өмнөх сараас 4.7%-иар өссөнд, мах, махан бүтээгдэхүүний үнэ 9.8%-иар, хүнсний ногооны үнэ 6.4%-иар, сүү, сүүн бүтээгдэхүүний үнэ 5.4%-иар өссөн нь голлон нөлөөлөв. Харин хүнснээс бусад бараа, үйлчилгээний үнэ 0.1%-иар буурав.

Сарын инфляцийн 1.2 нэгж хувийг дотоодын, 0.1 нэгж хувийг импортын барааны инфляци бүрдүүлсэн байна.

Жилийн инфляци УБ хотын хэмжээнд 2017 оны 3 дугаар сарын байдлаар 2.3 хувь гарсны 1.0 нэгж хувийг хүнсний бараа, бүтээгдэхүүн, 0.3 нэгж хувийг хүнснээс бусад бараа бүтээгдэхүүн бүрдүүлсэн бол 1.8 нэгж хувийг дотоодын бараа, үйлчилгээ, 0.5 нэгж хувийг импортын бараа, үйлчилгээ бүрдүүлжээ.

**Зураг 11. УБ хотын сарын инфляци**



**Зураг 12. УБ хотын жилийн инфляци**

